



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 01/02

Улаанбаатар хот

Хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5, 19.2.8 дахь заалтыг үндэслэн Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын үнэт цаасны арилжаагаар төвлөрсөн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт болон санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн сонголт, хэрэгжилтийн явц байдалтай танилцаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий шалгалтын хамтарсан Ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажлын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Энх-Амгалан - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Г.Батхүү - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Баярсайхан - Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун - Улсын Их Хурлын гишүүн
Я.Санжмятав - Улсын Их Хурлын гишүүн
Г.Уянга - Улсын Их Хурлын гишүүн
Л.Чойжилсүрэн - Улсын Их Хурлын гишүүн
Ч.Хүрэлбаатар - Улсын Их Хурлын гишүүн
Л.Эрдэнэчимэг - Улсын Их Хурлын гишүүн

Нарийн бичгийн дарга:

Л.Энхтуяа - Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн дарга

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх багийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай:

А.Зангад - Монгол Улсын Ерөнхий аудитор
С.Пүрэв - Сангийн дэд сайд
Б.Нямаа - Сангийн яамны газрын дарга
Н.Мөнхбат - Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал
С.Төмөрхүү - Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын газрын захирал

Ц.Цэрэн

-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт
үнэлгээний хэлтсийн зөвлөх

Л.Дансранбавуу

-Мөн хэлтсийн референт

А.Батсайхан

-Мөн хэлтсийн референт

Ц.Батбаатар

-Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны
референт

Д.Цэцэгмаа

-Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын
хорооны референт

3.Шалгалтын удирдамжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж,
шалгалтын дүнг 2015 оны 01 дүгээр сард багтаан Эдийн засгийн болон Төсвийн
байнгын хороодод танилцуулахыг Ажлын хэсэг /Л.Энх-Амгалан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ

УХА0316

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БОЛОР

УХА0316

Эдийн засгийн болон Төсвийн
байнгын хорооны 2015 оны
01/02 тогтоолын хавсралт

**ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАСАН ЗАСГИЙН
ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГААР
ТӨВЛӨРСӨН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАЙ
ТАНИЛЦАЖ САНАЛ ДҮГНЭЛТ ГАРГАХ
АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

2015 оны 01 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Шалгаж танилцах ажлын зорилго

Олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын үнэт цаасны арилжаагаар төвлөрсөн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт болон санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн сонголт, хэрэгжилтийн явц байдалтай танилцаж, санал дүгнэлт гаргахад оршино.

Хоёр. Ажлын хэсгийн ажиллах хугацаа

Шалгаж танилцах ажлыг 2015 оны 01 дүгээр сарын 16-наас 02 дугаар сарын 15-ны дотор багтаан явуулж, дүнг Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороонд танилцуулна.

Гурав. Танилцах ажлын чиглэл

3.1.Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилт;

3.2.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 19/10 тоот зөвлөмжийн хэрэгжилтийн байдал;

3.3.Засгийн газрын болон Хөгжлийн банкны гадаад, дотоод зах зээлийн гарц, бондыг анх байгуулсан гэрээний нөхцөл амлалт, хүлээсэн үүрэг нь Монгол Улсын холбогдох хуульд нийцэж байгаа эсэх;

3.4.Чингис бонд, Самурай бондыг Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлж байгаа нь зээл авсан нөхцөл гэрээний дагуу байгаа эсэх;

3.5.Хөгжлийн банкны тухай хуультай нийцэж байгаа эсэх;

3.6.Хөгжлийн банкинд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт, үлдэгдлийн хэмжээ, цаашдын зарцуулалтын байдал;

3.7.Чингис бонд, Самурай бондын талаар Монголбанктай хийсэн менежментийн гэрээ;

3.8.Хөгжлийн банк болон Чингис бонд, Самурай бондын хөрөнгөөр хийгдсэн төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалт Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хийгдсэн эсэх;

3.9.Хөгжлийн банк болон Чингис бондын санхүүжилтээр автозамын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээ;

3.10.Хөгжлийн банк болон Чингис бондын хөрөнгөөр дэд бүтцийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээ;

3.11.Хөгжлийн банк болон төмөр замын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээ;

3.12.Агаарын тээврийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээ;

3.13.Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд хийгдсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээ;

3.14.Хөгжлийн банкнаас "Эрдэнэс-Тавантолгой" ХХК-д өгсөн зээлийн гэрээ, эргэн төлөлтийн байдал;

3.15.Самурай бондын хөрөнгөөр хийгдэж буй төсөл арга хэмжээ;

3.16.Хөгжлийн банкнаас арилжааны банкуудтай хийсэн гэрээ, бондуудын үлдэгдэл ямар дүнгээр, ямар нөхцөлөөр хадгалагдаж буй байдал;

3.17.Чингис бонд, Самурай бондын үлдэгдлийн менежментийг хууль тогтоомжийн дагуу хийж буй эсэх;

3.18.Хөгжлийн банкны санхүүгийн тайланд аудит шалгалт хийх.

3.19.Хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж байгаа төсөл арга хэмжээний зээлийн эргэн төлөлтийн байдалтай тус тус танилцаж дүгнэлт гаргана.

-----oOo-----



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 02.

Улаанбаатар хот

**"Түлш, эрчим хүчний салбарын талаар
авах зарим арга хэмжээний тухай"
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1."Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1/эрчим хүчний салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төслүүд, Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Өрсөлдөөний тухай хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх;

2/Улаанбаатар хотын тавдугаар цахилгаан станцыг барих ажлыг шуурхайлах, бага өртөг зардлаар цахилгаан үйлдвэрлэх зорилгоор Багануур болон бусад уурхайн дэргэд эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж байгуулах, цаашид эрчим хүч экспортлох, түүнд шаардлагатай шугам сүлжээг бий болох;

3/эрчим хүчний салбарын менежментийг сайжруулах, зах зээлийн загварыг боловсронгуй болгох;

4/Дулааны гуравдугаар цахилгаан станцын /250 МВт/ болон Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл, Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн техникийн шинэчлэл, эрчим хүчний шинээр эхлэх буюу шинэчлэх төсөл арга хэмжээнд Хөгжлийн банкны гүүрэн санхүүжилтийн механизмыг хэрэгжүүлэх;

5/хэрэглэгчид ирэх ачааллыг хөнгөвчлөх зорилгоор эрчим хүчний салбарт олгож байгаа татаасыг бууруулахгүй байх, өндөр өртөг бүхий томоохон шинэчлэлийн ажлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн хөрш орнуудаас импортоор авч байгаа цахилгаан эрчим хүчийг нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас үргэлжлүүлэн чөлөөлөх.

2.Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, үнэ тарифыг бодит өртөг зардалд хүрэхүйц хэмжээнд тогтоож, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг татах таатай орчныг бий болгох чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Эрчим хүчний зохицуулах хороо /С.Отгонбаяр/-нд тус тус чиглэл болгосугай:

1/эрчим хүчний салбарын өртөг зардлыг бууруулах, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, элэгдэл тооцох жишиг хэмжээг тогтоох асуудлаар салбарын хэмжээнд баримтлах бодлого, чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх;

2/ахуйн хэрэглэгчдийн сар бүрийн 150кВтц хүртэл хэрэглээний төлбөрийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээших ахуйн хэрэглээ болон аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ тариф болон эрчим хүчний нүүрсний үнийг бодит өртөгт хүргэх зохицуулалтыг Төв, Дорнод бүсэд 2015 онд багтаан, бусад бүсэд үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3/эрчим хүчний үнэ тарифыг тооцохдоо чадлын тариф, ногоон тариф нэвтрүүлж, холболтын төлбөрийн тогтолцоог бий болгох;

4/шинээр барих эрчим хүчний эх үүсвэрийн цахилгаан эрчим хүч худалдах гарааны тарифыг тухайн төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, техникийн хүчин чадал, технологийн онцлог зэргийг харгалзан, хөрөнгө оруулалтын өгөөжийн зохих түвшинг хангасан байхаар тооцох.

3.Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг 2016 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 03/08

Улаанбаатар хот

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд
нэмэлт оруулах тухай**


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5, 19.2.8 дахь заалтыг үндэслэн Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооноос **ТОГТООХ НЬ:**

Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодоос 2015 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/02 тоот хамтарсан тогтоолоор байгуулагдсан шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатарыг нэмж оруулсугай.



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ



ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БОЛОР



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ө.Энхтүвшин - Улсын Их Хурлын гишүүн


Гишүүд:

Б.Гарамгайбаатар - Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл - Улсын Их Хурлын гишүүн
А.Тлейхан - Улсын Их Хурлын гишүүн
Д.Зоригт - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Ө.Энхтүвшин/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ганхуяг -Улсын Их Хурлын гишүүн


Гишүүд:

Ц.Баярсайхан -Улсын Их Хурлын гишүүн
С.Одонтуяа -Улсын Их Хурлын гишүүн
Г.Уянга -Улсын Их Хурлын гишүүн
Л.Энх-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Д.Ганхуяг/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Уянга

Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

С.Одонтуяа

Улсын Их Хурлын гишүүн

С.Дэмбэрэл

Улсын Их Хурлын гишүүн

Ц.Баярсайхан

Улсын Их Хурлын гишүүн


Л.Энх-Амгалан

Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Г.Уянга/-г даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, 46 дугаар зүйлд заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл болон Улсын Их Хурлаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

А.Тлейхан -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн
Д.Зоригт -Улсын Их Хурлын гишүүн
Г.Уянга -Улсын Их Хурлын гишүүн
Л.Энх-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр Засгийн газар, Үндэсний аудитын газар, Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, үнэлгээний хэлтэс болон холбогдох бусад яам, газруудаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг ~~Ажлын хэсэг /А.Тлейхан/-т~~ үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

ЖБАТСУУРЬ



**Батлав: Улсын Их Хурлын гишүүн,
Ажлын хэсгийн ахлагч**

А.Тлейхан

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Улсын Их Хурлаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн багийн бүрэлдэхүүн

Нэг. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга Л.Энхтуяа ажиллаж, тус хэлтэс Ажлын хэсэгт мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

Хоёр. Багийн гишүүд:

- | | |
|--------------------|---|
| 1. А.Зангад | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| 2. Д.Нямхүү | Аж үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга |
| 3. М.Хүрэлсүх | Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 4. Р.Эрдэнэбүрэн | Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 5. Ж.Бат-Эрдэнэ | Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 6. Д.Артаг | Уул, уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 7. Н.Ариунболд | Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 8. Д.Дэлгэрцогт | Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 9. З.Болдбаатар | Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 10. Ш.Булга-Эрдэнэ | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга |

11.Х.Ганцогт	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
12.Б.Отгонжаргал	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга
13.С.Магнайсүрэн	Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
14.Ж.Баярцэцэг	Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга
15.Д.Атармаа	Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга
16.Б.Болдбаатар	Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
17.Г.Ганболд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
18.С.Төмөрхүү	Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал
19.Х.Оюунцэцэг	ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
20.Л.Эрдэнэчулуун	Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор
21.Л.Энхтуяа	Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга
22.С.Энхцэцэг	Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны зөвлөх
23.А.Батсайхан	Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, үнэлгээний хэлтсийн референт
24.Д.Цэцэгмаа	Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны референт

АЖЛЫН ХЭСЭГ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр
тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих
ажлын хэсгүүд байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Ажлын хэсгүүдийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1.1. Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрт төсвийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангаж, алдагдлын хэмжээг зохистой түвшинд хүргэх чиглэлээр тусгагдсан 1.1-1.5, 5.1-5.2 дахь зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Баярсайхан

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ө.Энхтүвшин

-Улсын Их Хурлын гишүүн

Х.Болорчулуун

-Улсын Их Хурлын гишүүн

1.2. Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрт санхүүгийн тогтвортой байдал, мөнгөний бодлогоор эдийн засгийг дэмжих, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх чиглэлээр тусгагдсан 2.1-2.3, 8.1, 11.1-12.4 дэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Нямдорж

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Б.Гарамгайбаатар

-Улсын Их Хурлын гишүүн

Г.Уянга

-Улсын Их Хурлын гишүүн

1.3. Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрт хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан 4.1-4.5, 6.1-6.4 дэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Батхүү -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ц.Даваасүрэн -Улсын Их Хурлын гишүүн
Л.Энх-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн

1.4.Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрт эскпортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулах чиглэлээр тусгагдсан 7.1-7.6, 10.1-10.15 дахь зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

С.Одонтуяа -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

С.Бямбацогт -Улсын Их Хурлын гишүүн
Д.Зоригт -Улсын Их Хурлын гишүүн

1.5.Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрт дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр тусгагдсан 9.1-9.11 дэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

А.Тлейхан -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганхуяг -Улсын Их Хурлын гишүүн

1.6.Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрт нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх хүрээнд тусгагдсан 3.1-3.6 дахь зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч:

С.Дэмбэрэл -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Д.Бат-Эрдэнэ -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Нямдорж -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсгүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх багийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай:

А.Зангад -Монгол Улсын ерөнхий аудитор
С.Пүрэв -Сангийн дэд сайд
Х.Баделхан -Аж үйлдвэрийн дэд сайд
Ө.Пүрэвбаатар -Эрчим хүчний дэд сайд

Г.Байгалмаа	-Барилга, хот байгуулалтын дэд сайд
Г.Тэмүүлэн	-Уул, уурхайн дэд сайд
Х.Ержан	-Зам, тээврийн дэд сайд
Б.Нямаа	-Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын захирал
Г.Батхүрэл	-Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын захирал
С.Төмөрхүү	-Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал
Б.Батхүү	-Уул, уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Г.Ганболд	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
Х.Оюунцэцэг	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Л.Энхтуяа	-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн дарга
Ц.Цэрэн	-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн зөвлөх
Г.Даваажаргал	-Мөн хэлтсийн зөвлөх
А.Батсайхан	-Мөн хэлтсийн референт
Д.Цэцэгмаа	-Эдийн засгийн байнгын хорооны референт
Н.Эрдэнэцэцэг	-Мөн хорооны референт

3.Хяналтын ажилд Засгийн газар, холбогдох яам, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, тогтоолын хэрэгжилтийн явц байдлын талаар улирал тутам Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байхыг Ажлын хэсгийн ахлагч /Ц.Баярсайхан, Ц.Нямдорж, Г.Батхүү, С.Одонтуяа, А.Тлейхан, С.Дэмбэрэл/ нарт даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хороогоор хэлэлцэх бэлтгэл хангах, Байнгын хорооноос гарах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Баярсайхан

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Д.Зоригт

-Улсын Их Хурлын гишүүн

А.Тлейхан

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай:

Л.Энхтуяа
/ахлагч/

-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт,
үнэлгээний хэлтсийн дарга

С.Энхбаяр

-Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны
дарга

Б.Ганбат

-Үндэсний статистикийн хорооны Бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

С.Уранчимэг

-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт,
үнэлгээний хэлтсийн референт

А.Батсайхан

-Мөн хэлтсийн референт

Д.Цэцэгмаа

-Эдийн засгийн байнгын хорооны референт

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.БАТСУУРЬ

УХА0316



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2014 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор байгуулагдсан шалгалтын ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 39, 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /М.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1/Улсын Их Хурлын 2010 оны 39, 2012 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах шуурхай арга хэмжээ авч, "Эрдэнэс-Таван толгой" хувьцаат компанийн хувьцааны эзэмшлийн бүртгэлийг баталгаажуулах ажлыг 2015 онд багтаан хэрэгжүүлэх;

2/"Эрдэнэс-Таван толгой" хувьцаат компанийн Хөгжлийн банкнаас авсан зээлийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах;

3/Монгол Улсаас экспортлох нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50-иас доошгүй хувийг үндэсний тээврийн компани, консорциумаар гүйцэтгүүлэх;

4/"Эрдэнэс-Таван толгой" хувьцаат компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан шалгаж, хууль тогтоомж зөрчсөн төрийн албан хаагчдад хариуцлага тооцож, хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

5/Засгийн газарт болон "Эрдэнэс-Монгол" хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Эрдэнэс-Таван толгой" хувьцаат компанид Эдийн засгийн байнгын хороо, Үндэсний аудитын газрын хамтарсан шалгалтын ажлын хэсгээс өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /М.Сайханбилэг/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 11.

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг шинэчлэн
байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Батхүү

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ж.Батсуурь

-Улсын Их Хурлын гишүүн

Ц.Баярсайхан

-Улсын Их Хурлын гишүүн

С.Одонтуяа

-Улсын Их Хурлын гишүүн

А.Тлейхан

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Г.Батхүү/-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2014 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

**Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг
хангах зарим арга хэмжээний тухай**

Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, 19.2.5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Статистикийн тухай хууль, Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Үндэсний статистикийн хороо /С.Мэндсайхан/-нд даалгасугай:

1/Монгол Улсыг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлого, хөтөлбөртэй уялдуулан Статистикийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Монгол Улсын Их Хурлын 2011 оны 59 тоот тогтоолоор батлагдсан “Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж, 2016-2020 онд хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах;

3/Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах цар хүрээг өргөжүүлэх, салбарын статистикийн мэдээллийн баазыг хувийн хэвшлийн үйл ажиллагааны статистикийн мэдээллээр тогтмол баяжуулж байх, статистикийн асуудал хариуцсан төрийн албан хаагч, нэгжийн тогтвортой байдлыг хангах замаар бүртгэл, статистикийн байгууллагуудын уялдааг хангаж, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах.

2. Статистикийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, түүний үйл ажиллагааг хүрэлцээтэй төсөв, санхүү, мэргэжлийн боловсон хүчний чиглэлээр идэвхтэй дэмжихтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Сангийн яам /Ж.Эрдэнэбат/-нд даалгасугай:

1/Статистикийн салбарт сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт хийгдээгүйн улмаас салбарын тоног төхөөрөмж хуучирч, хэрэгцээ шаардлага хангахгүй байдалд хүрч байгааг харгалзан орчин үеийн шаардлага хангасан техник, тоног төхөөрөмж худалдан авах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

2/Үндэсний статистикийн тооллого судалгаа, мэдээний чанар, хамралт анхан шатны нэгжээс шууд хамааралтайг харгалзан Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн сумын түвшинд статистикийн асуудал

хариуцсан төрийн захиргааны орон тооны ажилтан ажиллуулах асуудлыг тухайн сум, орон нутгийн төсөв, орон тоонд багтаан шийдвэрлэх.

3.Энэ тогтоолын биелэлтийн талаар 2015 оны 10 дугаар сард багтаан Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Үндэсний статистикийн хороо /С.Мэндсайхан/, Сангийн яам /Ж.Эрдэнэбат/-нд тус тус үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ

